

2020 ОНЫ 2-Р УЛИРЛЫН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“ЛэндМН ББСБ” ХК



Агуулга

Онцлох үйл явдлууд	04
Харилцагчийн үйлчилгээ	08
Зээлийн үйл ажиллагаа	13
Санхүүгийн үйл ажиллагаа	16
Эрсдэлийн удирдлага	19
Компанийн засаглал	21

Гүйцэтгэх захирлын илгээлт



“

Монголын финтек салбарын анхны нээлттэй бонд болох "ЛэндМН Бонд"-ыг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргалаа.

”

Сайн байна уу, эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч байгууллагууд болон харилцагчид та бүхнийхээ амар амгаланг айлтган мэндчилж байна.

Дэлхий дахинд нүүрлээд буй (COVID-19) вирусээс үүдэлтэй Монгол улсад төдийгүй дэлхийн бусад улс орнуудад онц байдал зарлаж хорио цээрийн хатуу дэглэм тогтоогоод байгаа билээ. Тэдгээр хорио цээрийн дэглэмээс үүдэн эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагаа доголдож, ажилгүйдлийн хэмжээ зарим улс орнуудад түүхэн дээд хэмжээндээ хүрч, эдийн засгийн ойрын ирээдүй тодорхой бус байдалтай байна. "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьд үүсээд буй эдийн засгийн болоод санхүүгийн хүндрэлтэй үеийг харилцагчид болон хөрөнгө оруулагч нартайгаа хамтран даван туулах зорилгын хүрээнд хариуцлагатай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлсээр ирлээ.

Эдгээр арга хэмжээнүүдээс онцолбол, харилцагчдад үүсч болох зээлийн эргэн төлөлтийн доголдол, ирээдүйд учирч болох өрийн дарамтаас урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн хугацааг 1 удаа сунгах боломжтой байсныг олон удаа сунгах боломжтой болгосон, зээлийг бүхэлд нь нэг удаа эргэн төлдөг байсныг хэсэгчлэн эргэн төлөх боломжийг харилцагчдадаа олгосон болон тодорхой шимтгэлүүдийг хөнгөлсөн болно.

Мөн зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийг дэмжих зорилгоор "Асаа Азаа Үз" сугалаат хөтөлбөрийг зохион байгуулсан төдийгүй дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан дээр тулгуурлан зээлдэгчийн зээлийн мэдээллийг үндэслэн зээлийн скоринг дахин тооцон харилцагч тус бүрийн санхүүгийн чадавхад тохирсон зээлийн

бүтээгдэхүүнийг санал болгох зорилгоор системийн нарийвчилсан хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. Эдийн засгийн хүндрэлтэй үеийг айл өрхүүд хэрэглээний болон бусад төрлийн зээлийн дарамтад орохоос аль болох татгалзан илүү хуримтлал үүсгэн байж давах тул бид харилцагчдадаа нэмэлт өрийн дарамт үүсгэхгүй байх үүднээс зээл олголтоо хумих, зөвхөн шаардлагатай үед зээл олгох гэсэн бодлого баримтлан ажиллалаа.

"ЛэндМН ББСБ" ХК-ийн охин компани болох "Супер Ап Хэтэвч" ХХК нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу Монголбанкнаас "Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлөө авсан нь бидний хувьд үйл ажиллагаагаа тэлсэн онцлох үйл явдал байлаа.

Түүнчлэн бид нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн энэхүү хариуцлагатай үед Монголын финтек салбарын анхны нээлттэй бонд болох "ЛэндМН Бонд"-ыг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж, олон нийтээс 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүллээ. Үүнтэй холбогдуулан андеррайтер компаниудтайгаа хамтран олон нийтэд хөрөнгийн зах зээлийн онцлог, давуу талууд болоод санхүүгийн бусад хэрэгслүүдийг таниулах, сурталчлах ажлуудыг амжилттай зохион байгуулж "ЛэндМН ББСБ" ХК нь салбартаа анхдагч, тэргүүлэгч гэдгээ дахин нотоллоо.

Нийт хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, харилцагч та бүхэндээ 2020 оны эхний хагас жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

Хүндэтгэсэн:


"ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал
О.Болдбаатар

2020.07.23

01

Онцлох үйл явдлууд





ЛэндМН ББСБ" ХК нь Монголын финтек салбарын анхны нээлттэй "ЛэндМН Бонд"-ыг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргалаа



Бид дэлхийн эдийн засаг хумигдаж улс орнуудад эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн энэ үед Монголын финтек салбарын анхны нээлттэй "ЛэндМН Бонд"-ыг жилийн 17%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай Монголын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж олон нийтээс 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүллээ.

"ЛэндМН Бонд"-ын андеррайтераар "Ард Капитал Групп" ҮЦК ХХК болон "Мирэ Эссет Секьюритис Монгол" ҮЦК ХХК нар ажиллаж "Райнос Инвестмент" ҮЦК ХХК синдикатаар ажиллалаа. "ЛэндМН Бонд"-ын анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг Үнэт цаасны компаниудаар дамжуулан авахаас гадна SuperUp аппликэйшнээр захиалга өгөх боломжтойгоор зохион байгуулсан нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд нэгэн шинэ алхам боллоо.

Бондын анхдагч зах зээлийн арилжаа 2020 оны 6-р сарын 15-наас 19-ний өдрийн хооронд 5 хоногийн хугацаанд үргэлжилсэн бөгөөд нийт 541 хөрөнгө оруулагчаас 6.7 тэрбум төгрөгийн захиалга хүлээн авснаар анхдагч зах зээлийн захиалга 134.8%-тай биелж, хамгийн олон захиалагчтай компанийн бонд боллоо.

“ЛэндМН БОНД”-ын тухай

Монголын Финтек салбарын анхны нээлттэй бонд




“
 “ЛэндМН ББСБ” ХК хуримтлалтай иргэдэд мөнгөө өсгөх шинэ аргыг хөрөнгийн зах зээл дээр нээж өгч байна. **”**

О.БОЛДБААТАР
 ЛэндМН ББСБ ХК-ийн Үйлдтэй захирал



“
 ЛэндМН Бонд нь Монгол Улсын Татварын багц хуулиуд шинэчлэгдэж, нээлттэй өрийн бичгийн хүүгийн орлогод ногдох албан татвар 5% болж буурсны дараа гарч буй анхны нээлттэй бонд болж байна. **”**

Х.АЛТАЙ
 Монголын Хэрэг Гүйцэтгэх Байрны Үйлдтэй захирал



“
 Бидний шинээр хөгжүүлж буй SuperUp аппликейшнээр дамжуулан хөрөнгийн зах зээлд оролцох боломжтой. **”**

Ц.ОДМАА
 Анд Системс ХХК-ийн ҮЗ-ийн дарга



“
 Санхүүгийн хүртээмжтэй байдлын үүднээс андеррайтерийн компаниуд шимтгэлгүй үйлчилгээг танд үзүүлж байна. **”**

Б.ӨЛЗИЙБАЯР
 Ард Капитал Групп ҮЦК ХХК-ийн Үйлдтэй захирал




“
 Монголын хөрөнгийн зах зээлд олон нийтэд өндөр өгөөжтэй шинэ төрлийн санхүүгийн хэрэгсэл гарлаа. **”**

Т.ЖАМБААЖАМЦ
 Санхүүгийн Зохицуулах Хороо-ны ажлын албаны дарга



“
 Толгой компани болох “Анд Глобал” компани финтек салбарын эко системийг бүрдүүлэх зорилготой ажиллаж байна. **”**

Б.ХОС-ЭРДЭНЭ
 Анд Глобал компанийн хөрөнгө оруулалт хариуцсан захирал



“
 “СЭХ-ны шаардлагын дагуу захиалга авах 6/19-ны өдөр дуусах тул олон нийт хөрөнгийн зах зээлийн арилжаанд идэвхитэй оролцож бондын захиалгаа өгөөрэй гэж уриалъя.” **”**

Н.ЦЭВЭГМИД
 Миах Эстэп Сельстритис Монгол ҮЦК ХХК-ийн Үйлдтэй захирал Н.Цэвэгмид


 Эх сурвалж: www.mongolbank.mn

"ЛэндМН ББСБ" ХК-ийн охин компани болох "Супер Ап Хэтэвч" ХХК нь цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлөө авлаа

2017 онд "Үндэсний төлбөрийн системийн тухай" хууль батлагдан гарснаар Монгол Улсад төлбөрийн системийн хөгжлийг дэмжих, цахим төлбөр тооцоог хөгжүүлэх, төлбөрийн системд арилжааны банкнуудаас гадна олон талын оролцогчид оролцох, улмаар төлбөрийн үйлчилгээг илүү хурдан, найдвартай, зардал багатай хүргэх боломж бүрдсэн билээ. Уг хуулийн хүрээнд цахим мөнгө, түүний үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, аюулгүй, найдвартай цахим мөнгөний системийг бий болгож хэрэглэгчдийг хамгаалах зорилгоор Монголбанкнаас 2018 онд "Цахим мөнгөний журам"-ыг боловсруулан баталж, уг журмын дагуу финтек компаниуд төлбөр тооцооны системд цахим мөнгөөр оролцон, иргэдэд төлбөрийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй болсон юм.

"ЛэндМН ББСБ" ХК нь зээлийн үйлчилгээ болон цахим төлбөр тооцооны үйлчилгээ гэсэн үндсэн хоёр үйлчилгээ үзүүлдэг ба Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон "Монголбанкны Цахим мөнгөний журам"-ын дагуу харилцагчдадаа цахим төлбөр тооцооны үйлчилгээг хүргэхээр "Супер Ап Хэтэвч" ХХК-ийг үүсгэн байгуулсан билээ. "Супер Ап Хэтэвч" ХХК нь SuperUp болон LendMN аппликейшнуудаар дамжуулан технологид суурилсан санхүүгийн шийдлийг хүн бүрт хүртээмжтэй, хялбар, аюулгүй, найдвартай байдлаар хүргэх, төлбөр тооцооны цогц дижитал эко системийг бүрдүүлэх зорилготойгоор ажиллаж байна.

Монголбанкны ерөнхийлөгчийн 2020.05.20-ны өдрийн тушаалаар Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан финтек компани болох Супер Ап Хэтэвч ХХК нь Монголбанкнаас төлбөрийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлөө гардан авсан, цахим мөнгөний зөвшөөрөлтэй 2 дахь байгууллага боллоо.

"ЛэндМН ББСБ" ХК нь цахим хэтэвч, төлбөрийн үйлчилгээгээ 2020 оны 8-р сарын 1-ний өдөр тусгай зөвшөөрөл эзэмшигч "Супер Ап Хэтэвч" ХХК-д шилжүүлэхээр бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна.

02

Харилцагчийн үйлчилгээ





Асаа Азаа Үз - Сугалаат хөтөлбөр

LendMN аппликейшнээр авсан зээлээ эргэн төлөөд азтан болох боломжтой "АСАА АЗАА ҮЗ" сугалаат хөтөлбөрийг 2020.04.10-2020.05.04-ний өдрийг хүртэл хугацаанд амжилттай зохион байгуулж, LendMN facebook хуудсаар 6 удаагийн шууд Live-ийн тохирлоор нийт 48 азтанд 9 сая төгрөгийн онлайн дэлгүүрээс худалдан авалт хийх эрхийг олголоо.

Тус хөтөлбөрөөр зээлийн эргэн төлөлтөө хийсэн харилцагчдыг хамруулж, 1 удаагийн live-ийн азтанаар 500.000₮-ийн эрх 1 хүн, 250.000₮-ийн эрх 2 хүн, 100.000₮-ийн эрх 5 хүн нийт 8 азтанг тодруулж байсан бөгөөд LendMN аппликейшнд байрладаг Banana Mall-аас хүссэн худалдан авалтаа өөрийн азын эрхээрээ сонгож, үнэгүй хүргэлтээр авах боломжийг олгосон юм. "Асаа Азаа Үз" хөтөлбөрөөр харилцагчдынхаа зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, азтануудын шагналаа хүргүүлэн авсан зураг бүхий мэдээллийг LendMN facebook хуудсаар нээлттэйгээр мэдээллээ.

ХАРИЛЦАГЧ ТАНД
зээлийн эргэн төлөлтийн таатай нөхцөлийг санал болгож байна.

Энэхүү боломжийг ашиглахын тулд та тухайн зээлийнхээ дэлгэрэнгүй хэсгээс "Сунгах" товчийг дарна уу!

Жишээлбэл: Харилцагч та хэрвээ 2020.04.24-ны өдөр дуусах 100,000 төгрөгийн зээлийг нэг удаа бүтнээр нь төлдөг байсан бол энэхүү өөрчлөлтөөр доорх хүснэгтэнд үзүүлсний дагуу 12 сарын турш хуваан төлөх боломжтой боллоо.

Төлөх өдөр	Зээлийн үлдэгдэл	Төлөх дүн (+шимтгэл)
2020.04.24	100,000	10,000
2020.05.24	90,000	9,000
2020.06.23	81,000	8,100
2020.07.23	72,900	7,290
2020.08.22	65,610	6,561
2020.09.21	59,049	5,905
2020.10.21	53,144	5,315
2020.11.20	47,829	4,783
2020.12.20	43,046	4,305
2021.01.19	38,741	3,875
2021.02.18	34,866	3,487
2021.03.20	31,379	3,138
2021.04.19	28,241	28,241


www.lend.mn
 7707-0101

"ЛэндМН ББСБ" ХК нь харилцагч нартаа зориулан зээлийн эргэн төлөлтийн таатай нөхцөлийг санал болголоо

LendMN аппликейшнээр авсан зээлийнхээ эргэн төлөлтийн хугацааг сунгах боломжийг олгож сунгалтын товчийг нэмэлтээр шийдэж, тухай бүр LendMN фейсбүүк хуудсаар мэдээлж ажиллалаа. Коронавирус (Covid-19) цар тахлын улмаас Дэлхий нийт болон Монгол Улсын хэмжээнд санхүү, эдийн засгийн хүндрэл учирч байгаатай холбогдуулан Монголбанкны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ("Эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах тухай") мэдэгдэлтэй холбоотойгоор LendMN аппликейшнээс авсан зээлийн эргэн төлөлтөө таатай нөхцөлөөр буюу 12 сарын хугацаанд хуваан төлөх боломжийг бүх харилцагчдадаа олголоо.

Харилцагчийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирсан бол тухайн зээлийн үндсэн төлбөрийн 10%-ийг (хамгийн багадаа) шимтгэлийн хамт төлөөд 12 сарын хугацаанд хэдэн ч удаа сунгах боломжтой болсон юм.

"ЛэндМН ББСБ" ХК нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд харилцагчдынхаа санхүүгийн байдалд учирч болох асуудлуудыг хамтдаа шийдвэрлэх зорилгоор тухайн цаг үеийн шийдвэрүүдэд тохируулан түргэн шуурхай ажиллалаа.




ХУРИМТЛАГДСАН БОНУС ОНООГОО ЗАРЦУУЛАХ ШИНЭ БОЛОМЖ

2020.04.17-2020.04.24-ийг дуустал

450 оноогоор шимтгэл бууруулах

Баталгаажуулах



БОНУС ОНООГОО АШИГЛАН ЗЭЭЛИЙН ШИМТГЭЛЭЭ ХЭРХЭН БУУРУУЛАХ ВЭ?

01 LendMN аппликейшны “Зээл” цэс рүү орно.

02 Бонус оноо ашиглах товчийг идэвхжүүлж “Баталгаажуулах” товчийг дарна.

03 Бонус оноогоо ашиглах санамжийг зөвшөөрч “Тийм” товчийг дарна.

04 Та бонус оноогоо ашиглан амжилттай шимтгэлээ буурууллаа.

Хуримтлагдсан БОНУС ОНООГОО зарцуулах шинэ боломжийг олголоо

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн харилцагчдадаа зориулан хуримтлагдсан бонус оноогоо ашиглаж одоо байгаа зээлийнхээ шимтгэлийг бууруулах боломжийг олголоо.

LendMN аппликейшнийн үнэнч хэрэглэгчид одоо байгаа зээл бүрийнхээ шимтгэлийг 450 бонус оноогоор 10% бууруулах боломжийг туршилтаар олгож, цаашид ямар байдлаар хэрхэн хуримтлагдсан бонус оноогоо зарцуулж шимтгэлээ бууруулж болох талаар хэрэглэгчийн санал, судалгааны үр дүнд үндэслэн шийдвэрлэлээ.



240'059

Утсан сувгаар
үйлчилсэн
/+15,99% өссөн/



6'776

Мессэж үйлчилгээ
/+34% өссөн/



18 сек

Хүлээлгийн түвшин



32'207

Сошиал болон
үйлчилгээний
заалаар үйлчилсэн
/+ 25% өссөн/

Харилцагчийн үйлчилгээний төв

Дэлхий дахинд дэгдээд буй цар тахлын үед Улсын Онцгой Комиссоос гаргасан зөвлөмжийн дагуу харилцагчдын үйлчилгээний төвийн үйлчилгээний цагийг тодорхой хугацаанд хязгаарлаж Харилцагчийн үйлчилгээний ажилчдыг зайнаас ажиллуулах боломжуудыг судалж амжилттай хэрэгжүүлсэн болно. Ингэснээр Харилцагчийн үйлчилгээний төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн юм.

Одоогоор Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 30 ажилчидтайгаар харилцагч, хэрэглэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгөн ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 2-р улиралд харилцагчдаас нийт 240,059 удаагийн зээлийн үйлчилгээ болон аппликейшн ашиглалт, бусад үйлчилгээний талаарх асуулт, гомдол, санал ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

03

Зээлийн үйл ажиллагаа



Зээлийн үйл ажиллагаа

Шинэ төрлийн коронавирус (COVID-19) цар тахлын улмаас эдийн засгийн хүндрэл учирч зээлдэгчийн орлого багасах болон тасалдах байдал үүсч байгаатай холбоотойгоор найдваргүй зээлийн нэмэлт эрсдэл үүсгэхгүй байх, харилцагчдад үүсч болзошгүй санхүүгийн дарамтаас хамгаалах зорилгоор тодорхой арга хэмжээнүүд авсны нэг нь харилцагч тухайн зээлээ нэгээс олон удаа сунгах боломжийг анх удаа олгож эхэлсэн.


Үүнтэй холбоотойгоор 2020 оны 1-р улиралд 38.2 тэрбум төгрөгийн зээлийн хугацааг сунгаж байсан бол 2-р улиралд зээл сунгалт 63.7 тэрбум төгрөг болсон буюу 166% өслөө. Мөн Монголбанкны 2020 оны 4 сарын 13-ны өдрийн хэрэглээний зээлийн төлбөрийг 12 сар хүртэлх хугацаанд сунгах мэдэгдэлтэй холбоотойгоор системийн хөгжүүлэлт, тохиргоо хийх зорилгоор 7 хоногийн хугацаанд шинэ зээл олголтыг түр зогсоосон ба уг хөгжүүлэлтийг хугацаандаа дуусгаж зээл олголтыг хэвийн үргэлжлүүлсэн.

Цар тахлын үед олон улсад эдийн засаг хумигдаж байгаа, Монгол улс олон улсын хилээ хаасан болон FATF-ийн саарал жагсаалтад орсон зэрэг нь ойрын хугацаанд эдийн засгийн тодорхой бус байдлыг үүсгээд байгаа энэ үед “ЛэндМН ББСБ” ХК хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагч нарынхаа эрх ашгийг хамгаалах, найдваргүй авлагын эрсдэл хэт нэмэгдэхээс сэргийлэх үүднээс шинээр зээлийн хэрэглэгч бүртгэх ажлыг түр зогсоож, зээлийн багцын өсөлтийг хязгаарлах, эрсдэлээс сэргийлэх үүднээс зээлдэгч нарт дахин зээлийн скоринг хийх, удаа дараа зээлийн хугацаа хэтэрч байсан харилцагчийн зээлийн эрхийг хаах зэрэг арга хэмжээ түлхүү авч хэрэгжүүлсэн ба үүний үр дүнд цэвэр зээлийн багцын хэмжээ өмнөх улирлаас 18.2 тэрбум төгрөгөөр буурч 32.2 тэрбум төгрөгт хүрлээ.


Энэхүү улиралд хэдийгээр цэвэр зээлийн багц буурсан боловч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдээгүй болно. 2020 оны 6 сарын 30-ны байдлаар “ЛэндМН ББСБ” ХК нь 10 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй байгаа ба 3 болон 4-р улиралд энэхүү хэмжээгээр зээлийн багцыг нэмэгдүүлэх, ингэхдээ илүү сайн харилцагчийн зээлийн хэмжээг нэмэх, илүү өндөр өгөөжтэй шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

2020 оны 2-р улирлын тайлангийн үзүүлэлтүүдийг өмнөх оны тайлант үетэй харьцуулсан байдал


Шинээр олгосон болон сунгасан зээлийн тоо /мянга/



Шинээр олгосон болон сунгасан зээлийн дүн /тэрбум төгрөг/



Цэвэр зээлийн багц
/тэрбум төгрөг/



Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2020 оны 2-р улиралд чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь өссөн үзүүлэлттэй байгаа нь нийт зээлийн багц буурсантай холбоотойгоор тайлбарлагдаж байна.

Тэрбум төгрөг	2020.I	2020.II
Нийт зээлийн багц	52.5	33.9
Хэвийн зээл	50.3	31.5
Хугацаа хэтэрсэн зээл	0.6	0.6
Чанаргүй зээл	1.6	1.7
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	3.0%	5.1%
Зээлийн эрсдэлийн сан	(2.1)	(1.5)

04

Санхүүгийн үйл ажиллагаа



Санхүүгийн байдлын хураангуй тайлан

2020 оны эхний хагас жилийн байдлаар компанийн нийт хөрөнгө 47.1 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 32.3 тэрбум, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 9.7 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 28.3 тэрбум, өөрийн хөрөнгө 18.8 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 8.3 тэрбум төгрөг байна.

Хөрөнгө /Тэрбум төгрөг/	2019.I хагас жил	2020.I хагас жил
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9.7	9.7
Зээлийн багц(цэврээр)	36.6	32.3
Бусад хөрөнгө	0.8	3.7
Үндсэн хөрөнгө	0.4	1.2
Биет бус хөрөнгө	0.3	0.2
Нийт хөрөнгө	47.8	47.1


Өр төлбөр болон эздийн өмч /Тэрбум төгрөг/	2019.I хагас жил	2020.I хагас жил
Өр төлбөр	33.0	28.3
Эх үүсвэр	31.8	25.7
Бусад өр төлбөр	1.2	2.6
Эздийн өмчийн дүн	14.8	18.8
Хувьцаат капитал	10.5	10.5
Хуримтлагдсан ашиг	4.3	8.3
Нийт өр төлбөр болон эздийн өмч	47.8	47.1

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан


2020 оны эхний хагас жилийн байдлаар компанийн нийт орлого 9.8 тэрбум төгрөг байгаагаас 2.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Үүнээс 2-р улирлын орлого 3.8 тэрбум, цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөг байна.

Орлого, үр дүнгийн тайлан /Тэрбум төгрөг/	2019.I хагас жил	2020.I хагас жил
Нийт орлого	7.7	9.8
Хүүгийн зардал	(1.7)	(3.3)
Санхүүгийн цэвэр орлого	6.0	6.5
Банкны болон бусад шимтгэл	(0.9)	(0.8)
Шимтгэлийн дараах орлого	5.1	5.7
Эрсдэлийн сангийн зардал	(0.6)	(0.2)
Эрсдэлийн сангийн дараах орлого	4.5	5.5
Боловсон хүчний зардал	(0.8)	(1.0)
Үйл ажиллагааны бусад зардал	(0.9)	(1.3)
Татварын өмнөх ашиг	2.8	3.2
Татварын зардал	(0.3)	(0.4)
Цэвэр ашиг	2.5	2.8

Орлого, өссөн дүнгээр
/тэрбум төгрөг/



Цэвэр ашиг, өссөн дүнгээр
/тэрбум төгрөг/



05

Эрсдэлийн удирдлага



Эрсдэлийн удирдлага

“Лэндмн ББСБ” ХК нь эрсдэлийн удирдлагын сайн засаглалыг бий болгохыг зорин ажилладаг бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхийн тулд эрсдэлийн удирдлагын “Гурван шатлалт хамгаалалт”-ыг бүрдүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжүүлж ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын дагуу хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээг “ЛэндМН ББСБ” ХК-ийн бизнесийн стратеги төлөвлөгөөтэй нийцүүлэн тогтоон гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа нь нийт хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг төдийгүй компанийн найдвартай байдлыг нэмэгдүүлж байдаг.

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтоох, эрсдэлийн үр дүнтэйгээр удирдах үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо хяналт тавьж ажилладаг бөгөөд Эрсдэл, Хянан нийцүүлэлтийн газар нь Эрсдэлийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг билээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын баримт бичгийг баталж, эрсдэлийн удирдлага, эрсдэлийн тогтолцоо, цар хүрээ, зээлийн багц, эрсдэлийн хяналт зохистой түвшинд, үр дүнтэй байгаа эсэх талаар тайланг улирал бүр хэлэлцэн дүгнэдэг.

2020 оны 2-р улиралд цар тахлаас үүдэлтэй санхүүгийн хямралтай холбоотойгоор зээлийн эрсдэлийн удирдлага дээр онцгойлон анхаарч зохих шат дараалсан арга хэмжээг авч ажиллалаа. Энэ нь зээлийн эрсдэлийг тодорхойлж, зээл эрсдэхээс урьдчилан сэргийлэх хяналтыг хиймэл оюун ухаанд тулгуурлан скоринг ашиглан дахин тооцох ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.

Нөгөөтээгүүр Монгол улс саарал жагсаалтад орсонтойгоор холбогдуулан Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд хэтэвчний гүйлгээнд өдөр тутам хяналт тавьж, FATF, OFAC, EU, US зэрэг олон улсын хориг арга хэмжээний жагсаалтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн хяналтыг хэрэгжүүлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 2-р улиралд бүрэн хангаж ажилласныг дараах хүснэгт илтгэж байна.

Зохистой харьцааны үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2020.I	2020.II
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	29.2%	41.1%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	29.2%	41.1%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	28.3%	40.0%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	15.8%	38.1%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-8.3%	-0.7%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	78.7%	60.1%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	25.0%	41.2%

06

Компанийн засаглал



Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2020 оны II улиралд ээлжит 1, ээлжит бус 3 удаа хуралдаж, нийт 13 тогтоол гаргав. Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1, Компанийн дүрмийн 10-р зүйлийн 10.1 хэсгийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгож, Компанийн дүрмийн 14-р зүйлийн 14.1 хэсгийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнээ баталлаа. ТУЗ-өөс баталсан тогтоолуудаас онцлон дурдвал:

- 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 20/05, 20/06 тоот шийдвэрийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөл даргыг сонгон, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх:
 - Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо
 - Эрсдэлийн удирдлагын хороо
 - Аудитын хороо тус тус хороодын бүрэлдэхүүнээ батлав. Түүнчлэн 2020 оны ТУЗ-ийн ээлжит хурлуудын товыг баталлаа.
- ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 20/22 тоот тогтоол болон 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 20/25 тоот тогтоолоор нийт 239 сая төгрөгийн чанаргүй болон муу активыг зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
- 2020 оны 5 сарын 14-ний өдрийн 20/23 тоот тогтоолоор Компанийн 2020-2024 оны бизнес төлөвлөгөөг шинэчлэн батлав.
- “ЛэндМН ББСБ” ХК нь хөрөнгийн зах зээлд нийт 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий финтек салбарын анхны нээлттэй “ЛэндМН Бонд”-ыг олон нийтэд санал болгон гаргахаар шийдвэрлэж, өрийн бичгийн ерөнхий нөхцөлийг батлав. Уг тогтоолын хүрээнд бондын анхдагч зах зээлийн арилжаа 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр амжилттай болж өндөрлөсөн ба 2020 оны 6 сарын 26-ны өдөр хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэв.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүгнэлтүүд

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.

- Компанийн эрсдэлийн удирдлагын тайлан
- 2020 оны эх үүсвэрийн тайлан, төлөвлөгөө.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.

- Компанийн дотоод аудитор “Байгууллагын дотоод хяналтын тогтолцооны урьдчилсан үнэлгээ /COSO загвар/
- 2020 оны дотоод аудитын төлөвлөгөө.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрүүдийг Монголын Хөрөнгийн Биржийн (<http://mse.mn/mn/company/545>) цахим хуудаснаас танилцах боломжтой.

Холбоо барих:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг Утас: 9901-8886 Имэйл: board@lend.mn



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn